

<p>Guest Post: Sukhgerel Dugersuren: Criminal or Marmite Character?</p>	<p>Дүгэрсүрэнгийн Сүхгэрэл: Гэмт хэрэгтэн үү эсхүл Мармайт этгээд үү</p>
<p>Posted on <u>September 12, 2022</u> by <u>Julian Dierkes</u> By <i>Jennifer Lander</i></p>	<p>Женнифер Лендэр Нийтэлсэн Жулиан Дьеркес, 2022-09-12</p>
<p>Contrary to popular opinion and the slogans of international organisations, democracy and economic development do not always make for easy bedfellows. One of the basic elements of democracy has to do with the function of law under an independent judiciary: law should no longer simply be a mask for state interests but a genuine space where different interests and rights can be adjudicated as impartially as possible.</p>	<p>Ардчилал ба эдийн засгийн хөгжил хоёр тэр болгон нийцтэй байдаггүй нь түгээмэл үзэгдэл бөгөөд олон улсын байгууллагуудын уриа лоозонтой тэрсэлддэг талтай. Ардчиллын нэгэн суурь шинж чанар бол хараат бус шүүхээр хэрэгждэг хуульт ёс мөн бөгөөд шүүх нь хуулийг төрийн ашиг сонирхлын халхавч болгох бус харин олон янзын ашиг сонирхол болон эрхүүд аль болохоор голч шуударгаар шийдвэрлэгддэг орон зай болохыг хэлнэ.</p>
<p>In that sense, democracy is supposed to be good for economic development because it protects contractual relationships, transactions and other market activity from unlawful interference, thus creating a stable environment for the economy. However, democracy can also challenge the terms of economic development because the civil and political rights of citizens are also supposed to be protected by that very same mechanism: the rule of law.</p>	<p>Энэ утгаар ардчилал нь гэрээт харилцаа, арилжаа наймаа, зах зээлийн бусад үйл ажиллагааг хууль бус нөлөөллөөс хамгаалж эдийн засаг өрнөх тогтвортой орчныг бүрдүүлдгээрээ эдийн засгийн хөгжилд ээлтэй байх учиртай юм. Нөгөөтэйгүүр, иргэдийн иргэний болон улс төрийн эрх нөгөө л хуульт ёс гэх механизмаар хамгаалагддаг учраас ардчилал нь эдийн засгийн хөгжлийн нөхцөл, арга замыг шүүн сөрөх тал бас бий.</p>
<p>Because the rule of law cuts both ways – protecting contracts as well as civil rights – there are times when democracy and economic development seem to be at odds. In these times it is not uncommon to</p>	<p>Хуульт ёс нь хоёр иртэй буюу гэрээт харилцаа болон иргэний эрхийг аль алиныг ийнхүү нэгэн зэрэг хамгаалдаг учраас ардчилал ба эдийн засгийн хөгжил үе үе тэрсэлдэхэд хүрсэн мэт болдог. Ийм цагт засгаас “эдийн засгаа сэргээх”-ийг зорихдоо иргэний эрхийг хязгаарлахыг оролддог нь тохиолдоно.</p>

<p>see national governments trying to limit civil rights in order to “get the economy back on track”.</p>	
<p>Enter our current case in point: the investigation of Sukhgerel Dugersuren, a high-profile civil society leader who has been deeply involved over the past two decades in monitoring the environmental and social impacts of large-scale mining and infrastructure projects. In early August, the General Intelligence Agency (GIA) began an investigation of Sukhgerel’s alleged role in “sabotaging” the country’s economic interests through “illegal cooperation with foreign agents/agencies” (Articles 19.4 and 19.6 of the Criminal Code). These are serious allegations and could lead to imprisonment if Sukhgerel is found guilty.</p>	<p>Үүнийг сүүлийн 20-од жил том хэмжээний уул уурхай, дэд бүтцийн төслүүдийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн хяналт шинжилгээнд идэвхтэй оролцож ирсэн иргэний нийгмийн нэгэн нэрт манлайлагч болох Дүгэрсүрэнгийн Сүхгэрэлийг мөрдөн шалгаж буй кейс дээр шинжэе. Наймдугаар сарын эхээр Тагнуулын Ерөнхий Газраас “гадаадын алба/агенттай хууль бусаар хамтран ажиллах” замаар улс орны эдийн засгийн ашиг сонирхолд “санаатайгаар саад хийх”-д Сүхгэрэлийн үүрэг оролцоог тогтоох мөрдөн шалгалт эхлүүлжээ (Эрүүгийн хуулийн 19.4, 19.6 зүйл заалт). Заасан үндэслэлүүд нь ноцтой учраас Сүхгэрэлийг гэм буруутайд тооцвол шоронд хориход хүргэх юм.</p>
<p>Here are two simple questions that I hope will shed a little more light and a little less heat on this controversial moment in a controversial figure’s career.</p>	<p>Дараах энгийн хоёр асуулт тавьснаар маргаан өдөөсөн энэ хүний ажил амьдралд тохиож буй эгзэгтэй байдлын учрыг тодруулан намжаахад тус болно гэж найднам.</p>
<p>Why Now?</p>	<p>Яагаад одоо?</p>
<p>The first is a question of timing: why now? Sukhgerel has been working consistently as an advocate on socio-environmental issues since the early 2000s when the mining boom started in Mongolia. People may not agree with her politics or her assessment of the impacts of mining, hydropower and other energy projects, but she isn’t doing anything <i>new</i>. In fact, Sukhgerel has been extremely consistent in her advocacy approach, which is notable for its almost obsessive <i>lawfulness</i>: her modus operandi is to sift through every governing rule that applies to a given development project, whether that be national legislation, international law or standards, or</p>	<p>Нэгд цаг хугацааны асуудал гарч байгаа юм: яагаад одоо вэ? Сүхгэрэл нь Монгол улсад уул уурхайн бүүм эхэлсэн 2000 онуудын эхэн үеэс нийгэм-байгаль орчны асуудлаар туйлбартай ажиллаж ирсэн аж. Хүмүүс түүний арга барилтай эсхүл уул уурхайн, усны болон бусад төрлийн эрчим хүчний төслийн талаар гаргаж буй дүгнэлтүүдтэй санал нийлэхгүй байж болно. Гэхдээ энэ хүний хийж, хэлж байгаад гоц шинэ зүйлс байхгүй. Харин ч Сүхгэрэл нөлөөллийн ажилдаа бараг донтолтой адилтгаж болохуйц хууль, эрх зүйг эрхэмлэсэн чанараар тодорхойлогдох дээд зэргийн тууштай хандлагатай байж ирсэн</p>

<p>corporate social responsibility commitments. Her June article on the Erdeneburen hydropower plant is just such an example of detailed legal analysis.</p> <p>If Sukhgerel hasn't been doing things differently, then what has changed?</p>	<p>юм. Өөрөөр хэлвэл, улсынхаа хууль тогтоомж, олон улсын гэрээ хэлэлцээр, компанийн нийгмийн хариуцлагын хэм хэмжээнүүдийг сам шүүрээр шүүрдэх мэтээр тухайн төсөлд хамаарах эрх зүйн зохицуулалт бүрийг олж тавьдаг арга барилтай. Эрдэнэбүрэнгийн УЦС-ийн тухай зургадугаар сарын нийтлэл нь энэхүү эрхзүйн няхуур дүн шинжилгээний нэгэн жишээ юм.</p> <p>Тэгэхлээр, Сүхгэрэлийн арга ажиллагаа хэвэндээ байхад чухамхүү юу өөрчлөгдөв өө?</p>
<p>In August, a few days after her investigation was announced by the GIA, the Chinese Foreign Minister arrived. The Erdeneburen hydropower plant was on the table for discussion. Coincidence? I think not. My research suggests that there is a consistently positive correlation between heightened national economic insecurity and increasingly erratic crackdowns on civil society. It was a similar story in 2013, when Mongolia's mining economy began to tank and the most outspoken leaders of the River Movements were detained and imprisoned in a dubious judicial process.</p>	<p>Наймдугаар сард ТЕГ-аас шалгалт явуулахыг мэдэгдсэнээс хэдэн өдрийн дараа Хятадын Гадаад хэргийн сайд морилон ирэв. Эрдэнэбүрэнгийн УЦС-ийн асуудал хэлэлцэх төлөвлөгөөнд багтсан байв. Тохиолдлын хэрэг үү? Үгүй гэж бодож байна. Миний судалж ажигласнаар улсын эдийн засгийн эмзэг байдал хурцдах ба иргэний нийгэмд үзүүлэх дарамтлал бачим ихсэхийн хороонд эерэг хамаарал байгаа юм. Ижил тэстэй байдал 2013 онд бий болсон. Монголын уул уурхайн салбар сүрхий туйлдаж эхэлмэгц учир битүүлэг шүүхийн ажиллагаагаар Гол мөрний хөдөлгөөний хамгийн зоримог удирдлагуудыг баривчлан ялласан юм.</p>
<p>Just as there have been “boom and bust” cycles affecting Mongolia's economic returns from natural resource exports, there have been parallel “boom and bust” cycles in the central government's relationship with sub-national administrations and civil society organisations. I think we are seeing another one of these cycles, where Mongolia's political economy is profoundly shaping its constitutional balance and adversely affecting civil society.</p>	<p>Байгалийн баялгийн экспортоос олох орлогын өсөлт-уналтын мөчлөгийг дагаж яг адил сайжрах-муудахын мөчлөг засгийн газраас орон нутгийн засаг захиргаа болон иргэний нийгэмтэй харилцах харилцаанд бий болдог. Миний бодлоор Монголын улс төрийн эдийн засаг бүтцийн чанартай тохируулгаар орж буй нь иргэний нийгэмд сөргөөр нөлөөлж байна.</p>

Why Sukhgerel?	Яагаад Сүхгэрэл?
<p>Sukhgerel is particularly high profile, and her “fine legal toothcomb” approach is something which makes her very tiresome in the eyes of corporations, investors and government ministries wanting to accelerate economic activities. Equally, she is very admired in the eyes of impacted communities and transnational advocacy networks. If the government succeeds in taking Sukhgerel out of the picture through criminalisation, they will simultaneously take a prominent thorn out of the side of economic interests and effectively threaten those who support her.</p>	<p>Сүхгэрэл онцгой тодруун бөгөөд хуулийг шүүн ашигладаг чамбай чанараараа аж ахуйн ажил түргэсгэхийг хөөцөлдсөн корпорацууд, хөрөнгө оруулагчид болон засгийн газрын яамдын хувьд ихээхэн төвөг тойв болдог. Харин нөлөөлөлд өртсөн хүн амын дунд, олон улсын нөлөөллийн сүлжээний хүрээнд ихээхэн нэр цууг хүртсэн хүн юм. Засгийн газар Сүхгэрэлийг гэмт хэрэгтэн болгож замаасаа зайлуулж чадваас эдийн засгийн ашиг сонирхлын бөөрөнд шигдсэн өргөсийг суглахын зэрэгцээ дэмжигчдэд нь айлган сүрдүүлсэн дохио өгнө.</p>
<p>The problem is that by targeting Sukhgerel, the government is punishing a particularly <i>civil</i> and <i>lawful</i> mode of engagement with the impacts of development projects. While Sukhgerel may be famously combative in her tone, she notably doesn’t organise violent protests. She attends well-known international conferences, she promotes well-recognised campaigns on taxation and environmental impact assessment. In short, she is part of a well-known chorus of concerned civic leaders working on the social and environmental impacts of development projects globally.</p>	<p>Засгийн газар Сүхгэрэлийг бай болгож буйн эгзэгтэй тал нь бол хөгжлийн төслүүдийн үр нөлөөг хамгийн суртахуунтай болоод хуульт ёсны өнцгөөс авч үздэг арга хандлагыг яллан шийтгэж байгаа явдалд оршино. Сүхгэрэл ширүүн яриагаараа алдартай байж болох боловч үймээн самууныг зохион байгуулдаггүй. Олон улсын нэр хүндтэй хурал цуглаанд оролцдог, татварын асуудал, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний талаарх өргөнөөр хүлээн зөвшөөрөгдсөн кампанит ажлуудыг дэмждэг. Товчхон хэлвэл, энэ хүн хөгжлийн төслүүдийн нийгмийн болон байгаль орчны нөлөөллийн асуудлаар даян дэлхийн хэмжээнд ажиллаж олны танил болсон иргэний нийгмийн зүтгэлтнүүдийн эгнээнд багтдаг юм.</p>
<p>She may be unpopular because she believes in prioritising social and environmental principles over economic activities, but that’s nothing surprising. Large-scale development projects <i>are</i> inevitably controversial, especially in democracies where people have sufficient freedom to raise their voice and promote their views. Sukhgerel is</p>	<p>Сүхгэрэл нийгмийн болон байгаль орчны эрх ашгийг эдийн засгийн үйл ажиллагаанаас илүү чухалд үздэг нь дургуйцэл төрүүлдэг байж болно. Гэвч үүнд гайхах зүйлгүй. Том хэмжээний хөгжлийн төслүүд угтаа маргаантай байдаг, ялангуяа</p>

<p>someone who sees more costs than benefits, and she is entitled to hold that opinion and seek to influence the governance of the sector as an informed civilian, particularly given that all she seems to spend her time doing is appealing to the very standards that companies, investors and governments say they are committed to.</p> <p>So are Sukhgerel’s advocacy activities annoying for some actors? Sure. Are they disruptive for some projects? Potentially. Are they criminal? No.</p>	<p>хүмүүс дуу хоолойгоо сонсгох, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг олгодог ардчилсан нийгмүүдэд. Сүхгэрэл нь өгөөжөөс илүү өртгийг олж хардаг нэгэн. Ийм үзэл бодолтой байх ба ухамсар бүхий иргэний хувьд салбарын удирдлагуудад нөлөөлөхийг оролдох эрхтэй. Ялангуяа энэ хүний бүх цагаа зарцуулан хийдэг зүйл нь бол компаниуд, хөрөнгө оруулагчид, засгийн газруудын өөрсдөө амласан стандарт, хэм хэмжээнүүддээ нийцүүлэхийг нэхдэг ажил болохыг бодолцвол. Ингэхлээр Сүхгэрэлийн нөлөөллийн ажил зарим талуудад тээртэй байх уу? Мэдээжийн хэрэг. Зарим төслүүдэд саад учруулах уу? Магадгүй. Гэмт хэрэг мөн үү? Үгүй.</p>
<p>So what is this all really about?</p>	<p>Тэгэхлээр энэ бүхний учир юунд байна вэ?</p>
<p>My concern is that this criminal investigation is not <i>really</i> about whether Sukhgerel is a “traitorous saboteur” of Mongolian economic interests. Frankly, that allegation seems extremely far-fetched (heavily edited Youtube videos and email screenshots on Twitter are not “evidence” in any sense of the word). The real issue is the democratic cost of the government’s current erratic attempt to reassure its economic partners that <i>nothing</i> – not even the fine legal toothcomb of Sukhgerel Dugersuren – will delay or disrupt economic projects. There is a heavy irony to all of this, in the sense that the government itself has routinely delayed and disrupted strategic economic projects over the past ten years, much to the ire of investors. But this time the government has the chance to blame someone else, and they are taking it.</p>	<p>Энэхүү эрүүгийн мөрдөн шалгалт Сүхгэрэлийг Монголын эдийн засгийн ашиг сонирхолд саад учруулсан урвагчаар тодорхойлохоос илүү хаялагтай болох нь санаа зовоож байна. Шуулуухан хэлэхэд ингэж буруутгах нь арай л дэндсэн хэрэг (ю-тьюб дахь сүрхий монтажилсан бичлэг, твиттерт тавьсан и-мейлийн дэлгэцийн зураг зэрэг нь аль ч утгаар “нотлох баримт” биш). Юү ч, түүний дотор Сүхгэрэлийн эрх зүйн орчныг нягтлан шүүрдэх сам шүүр ч, аж ахуйн төслүүдийг удаашруулахгүй, тасалдуулахгүй гэгчийг эдийн засгийн түншүүддээ нотлох гэсэн засгийн газрын тэвдүү үйлдлүүдээс ардчилалд учрах уршигт гол асуудал оршино. Бий болсон байдлын шог тал нь бол засгийн газар өөрөө сүүлийн арваад жилийн турш эдийн засгийн стратег төслүүдээ хөрөнгө оруулагчдын эгдүүцлийг хүргэн байж тогтмол удаашруулж эсхүл тасалдуулж ирсэнд байгаа юм. Харин энэ удаа</p>

	<p>өөр хэн нэгнийг буруутгах шанс олдож буй тул түүнийг ашиглахаар санаа шулуудсан аж.</p>
<p>Sukhgerel makes a particularly efficient scapegoat because she is a classic “marmite character” in Mongolia’s economic development sector (to borrow a British idiom). Marmite, if you don’t know of it, is a salty yeast spread for toast or sandwiches eaten in the UK, and people either love it or loathe it. There is no middle ground with Marmite, just like there is no middle ground with Sukhgerel: people tend to be either for or against her.</p>	<p>Сүхгэрэл нь Британийн нэгэн хэлцийг хэрэглэвэл Монголын хөгжлийн салбарт дахь сонгодог хэлбэрийн “мармайт этгээд” мөн учраас бурууг тохоход онц тохиромжтой гэлтэй. Мармайтын тухай сонсоогүй хүнд тайлбарлаваас, энэ нь Нэгдсэн Вант Улсынхан талхандаа түрхэж иддэг хөрөнгөөр хийсэн, давслаг амттай нэгэн зүйл юм. Хүмүүс түүнд эсхүл чигтээхэн дурладаг эсхүл үзэн яддаг, дундын ойлголт байхгүй. Сүхгэрэл ч яг тийм: хүмүүс эсхүл түүний талд эсхүл эсрэг.</p>
<p>But being a “marmite character” is not a criminal offense. If no real evidence of “traitorous sabotage” turns up out of the blue (as I strongly suspect it won’t), then this criminal investigation is effectively a scare tactic to punish the very mode of civic engagement that Mongolia’s democratic constitution has been designed to protect. It scapegoats someone who has unfailingly, infuriatingly and tenaciously turned to <i>lawful</i> means to challenge economic activities by using the very standards baked into development projects themselves.</p>	<p>Гэвч “мармайт этгээд” байх нь гэмт хэрэг биш юм. Санаатай саад хийсний нотолгоо хаа нэгэн газраас гараад ирэхгүй бол (гарч ирэхгүй гэсэн хүчтэй сэжиг надад байна) энэхүү эрүүгийн мөрдөн шалгалт нь Монгол Улсын ардчилсан Үндсэн хуулиар хамгаалагдсан иргэний оролцоо гэх үйл хэрэгт халдсан сүрдүүлэгийн үйл ажиллагаа болж таарна. Үүний золиосонд хэнийг гаргах гэж байна вэ гэвэл хөгжлийн төслүүд өөрсдөд нь тусгагдсан хэм хэмжээнүүдийг эшлэн эдийн засгийн арга хэмжээнүүдийг тэнсэн сорьж, ингэхдээ гагцхүү хууль ёсны арга замыг тууштай, цөхрөлтгүй, бүр дургуй хүрэхүйцээр хэрэглэж ирсэн хүн болох гээд байгаа юм.</p>
<p>If this investigation is to have any credibility from a legal perspective, it must be very transparent, independent and stringently follow the rules of admissible evidence and fair trial. Innocent until <i>proven</i> guilty, right? The rule of law, if it is real and not just rhetoric, has to protect everyone, even marmite characters.</p>	<p>Мөрдөн шалгалт хуулийн өнцгөөс хууль ёсны болохын тулд ил үтод, хараат бусаар явагдаж нотлох баримтын зөвшөөрөгдөхуйц байдал болон шударга шүүхийн зарчмуудыг чандлан сахих ёстой. Гэм буруутай нь нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцдог, тийм ээ? Нэр төдий бус жинхэнэ хуульт ёс нь хүн бүрийг, түүний дотор мармайт этгээдийг ч хамгаалах учиртай.</p>

Женнифер Ландэрийн тухай:

Др. Женнифер Ландер нь Их Британийн Де Монфорт Их Сургуулийн [Хуулийн зочин судлаач](#). Тэр Британийн Академийн санхүүжилттэй Монголын уул уурхайн салбарын маргаан шийдвэрлэх механизмын иргэншлийн заншил ба загварт хэрхэн нөлөөлөх тухай судалгааг удирдаж байна. Түүний [Шилжилтийн хууль ба Төрийн хувиралт](#) ном нь (Routledge, 2020) дээрх блогод хөндсөн асуудлуудын өргөн хүрээний асуудлуудыг нарийвчлан судалсан болно . Тогтмол бус Жиргээг нь [@jennylander4](#) дагах эсвэл jenny.lander@dmu.ac.uk хаягаар шууд харилцаж болно.